

01 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Төрийн үйлчилгээний чиглэлээр: Сумын 2021 оны үйл ажиллагааны тайланг 19 үзүүлэлтээр гаргаж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлүүлж дүгнүүлэн цаг хугацаанд нь цахимаар болон цаасаар ХШҮ-ний хэлтэст хүргүүлж ажилласан. Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан “Аз жаргалтай ажиллахын нууц” цахим сургалтанд тамгын газрын 23 албан хаагчид хамрагдсан. Мерит төслийн газар болон сумын тамгын газар хамтран ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэхээр болж 4 удаагийн сургалтыг ЗДТГ-ын албан хаагчдад өгөөд байна. Нийт тамгын газрын 38 албан хаагчид хамрагдсан. 2022.01.04 өдөр ажлын байрны ISO 9001:2015 сургалтанд тамгын газрын албан хаагчид хамрагдаж ажлын байрны төлөв байдлын үнэлгээ хийх дадлага ажилд суралцсан. УИХ-ын гишүүн Ж.Батсуурийн ажлын алба, Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлийн санал санаачилгаар сумын Засаг даргын тамгын газрын 10 хүний бүрэлдхүүнтэйгээр Дундговь аймгийн Гурван сайхан суманд очиж туршлага судалсан. Сумын ИТХ-аас Шинэ үндсэн хууль үүссэний 30 жилийн ойд зориулсан АХА тэмцээнд тамгын газраас 5 албан хаагч оролцож 1 албан хаагч 1-р байр эзэлж амжилттай оролцсон.

Батлан хамгаалах чиглэлээр:

Улсын бүртгэгч: Шинээр төрсөн хүүхэд 3, гэрлэлт 1, нас баралт 4, шинээр олгосон үнэмлэх 13, лавлагаа 33 үүнээс албан хэрэгцээнд 25, иргэнд 8 үйлчилгээ үзүүлж бүртгэлжүүлсэн байна.

Хууль эрх зүй, Хүүхэд залуучууд гэр бүлийн чиглэлээр:

Сумын ИТХ,ЗДТГ, цагдаагийн хэсэг хамтран АА-н сургалтыг зохион байгуулсан.

Сургалтыг Дорнод аймаг болон Сүхбаатар аймгийн АА-н 3 бүлэг 20 хүний бүрэлдхүүнтэй ирж нээлттэй уулзалт хийж ажилласан. Сумаас 44 хүн хамрагдаж сумын хэмжээнд АА-н бүлэгтэй болсон. Сургалтын зардал 200,0 мян төгрөгийг ГХУСС-аас гарган ажилласан. ЗДТГ-н жендерийн судалгааг хийж холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.

Суманд хэрэгжиж буй Энтрепренершил төслийн 2-р ээлжийн сургалт эхлэх гэж байгаатай холбогдуулж 18-25 насны сургууль завсардсан залуучуудын судалгааг гаргаж, багуудын засаг дарга нарт мэдэгдэж сургалтанд хамрагдах залуучуудын нэрсийг гаргаж 25 хүнийг хамруулахаар болоод байна. ЕБС-н Нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамтарсан багийн Туршилтын 10 өрхөөр орж танилцсан санал бодлыг сонсож ажилласан. Сумын хэмжээний хагас болон бүтэн өнчин хүүхдийн судалгааг хийж явуулсан. Залуучуудын хөгжлийн зөвлөлийг шинээр байгуулж, ГБХЗГазартай 2022 онд хамтарч ажиллах чиглэлийг хүргүүлсэн.ХАӨМС-н хүснэгтийн шинэжлэлийн асуулгын

дагуу багийн засаг дарга нараас саналыг асууж асуулгын хариуг илгээсэн. Дархан бэр болон Уран бэрийн одон авах иргэдийн бүртгэлийг дуусгаж одон болон өргөмжлөлийг авчруулсан.

Хоёр: Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2022 оны 1-р сарын 3-5-ны хооронд төсөвт байгууллагууд сарын мэдээ гаргаж жилийн эцсийн орлого зарлага хаасан. 1-р сарын 7,8-нд шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсөв, бүтэц орон тоо, хөрөнгө оруулалтыг шилэн дансанд байршуулж ил тод байдлыг хангаж ажилласан.

1-р сарын 25-нд 2021 оны жилийн эцсийн тайланг программд орлого зарлага авч Төрийн аудитын газарт тушаасан. 1-р сарын 25-наас 31-ныг хүртэл төсөвт байгууллагын цалин хөлс болон тогтмол зардлын гүйлгээг хийж гүйцэтгэсэн.

2022 оны байгууллагуудын төсвийн хуваарийг Засаг даргаар батлуулж аймгийн төрийн санд хүргүүлсэн.

Гурав: Нийгмийн бодлогын хүрээнд

Нийгмийн даатгал: 1 сарын 26 ны байдлаар СДД-д 112 иргэн, ЭМД-д 28 иргэн даатгуулаад байна. Өндөр насны тэтгэвэрт 1 иргэн утсаар 13 иргэнд зөвөлгөө өгч ажилласан.

Нийгмийн халамж: Насны хишиг шинээр 13 ахмад, бүртгэлтэй 185 нийт 198 ахмадад нийт 16040,0 мян төгрөг, 1-р одон 151, 2-р одон 290 нийт 441 эхчүүдэд 59200,0 мян төгрөг, хүүхдийн мөнгө бэлнээр авах хүсэлт 1400 ирснийг илгээсэн. Иргэд Е баримт болон Е халамж сайтаар 540 иргэний хүсэлт илгээгдсэн. Цагаан сарын баяраар хүндэтгэл үзүүлэх төрийн харьяалалд 342 ахмадын бэлэгний 3420,0 мян төгрөгийг ахмадын нэрийн данс руу шилжүүлсэн. Төсөвт байгууллагуудын харьяалалд 99 ахмад байна. ЗДТГ орон гэргүй 1 ахмадыг 4 ханатай гэрээр хангаж тохижуулан хоол хүнс, түлээ түлш, дулаан хувцас зэргийг аж ахуйн нэгж, иргэдийн дэмжлэгээр цуглуулж тусад нь гаргаж орон гэртэй болгосон.

ЕБС: 2021-2022 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагааг эхлүүлж энэ хичээлийн жилд тус сургуулийн 89 багш ажилтан 1000 сурагчдад боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Байгууллагын дотоод журмаа багш ажилчдаар хэлэлцэж 17 бүлэг бүхий журмыг батлав.

Байгууллагын дотоод журмын 15,16 –д заасны дагуу багш, ажилтнуудыг жилд нэг удаа дархлаажуулалтыг дэмжих заалтын хүрээнд байгууллагын 89 багш, ажилчдыг 1 сая төгрөгийн бариа засалд хамруулж дархлааг нь дэмжиж ажилласан. Хүүхдийн үдийн хоол, байрны хүүхдүүдийн хоолыг нийлүүлэгч “ГАЛ ТҮШИГ”, “ЭЛБЭГ БАЯН ЗЭЭРД”- ХХК хүүхдийн сурах их үйлсэд нийгмийн хариуцлагын хүрээнд Англи хэлний вестулийг тохижуулж өглөө. Сургалтын орчны өнөөгийн нөхцөл байдал, хичээл сургалтын үйл ажиллагаанд хэрэглэж буй сурах бичгийн хүртээмж, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж

хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг судлагдахуун бүрээр гаргаж зохион байгуулах ажлын хэсгийг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Мөн сургуулийн дотоод журмын 2.4. дэх хэсгийг үндэслэн захирлын дэргэдэх зөвлөлийг 7 бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан Сургуулийн нүүрсний сарын нөөц 120 тн байна.

БАГШИЙН ХӨГЖИЛ - 2022.01 сард сургалтын үйл ажиллагааны хүрээнд нийт 22 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 252 багш танхим ,цахим хосолсон хэлбэрээр хамрагдсан.

Хүүхдийн цэцэрлэг: Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, багш ажилчдад танилцуулан хэлэлцүүлж, цахим хэлбэрээр санал авч ажиллав. Үүнд 39 багш ажилчдаас, 36 нь хамрагдсан байна.

Багш ажилчдын 2022 оны хувийн зорилго тодорхойлох ажлыг зохион байгуулж, “ 1. Өөрийгөө хөгжүүлэх, 2. Бүтээлч байдлаар 3. Шинэлэг санаачилга” гэсэн чиглэлээр хувь хүн бүр зорилго дэвшүүлэн, тухайн зорилгодоо хүрэхийн тулд хийх ажлуудаа төлөвлөж батлуулав. Нийт багш ажилчдын 37 нь эдгээр ажлыг бүрэн гүйцэд хийж, хугацаандаа батлуулав.

Багш ажилчдын 2021 оны ажлын тайланг хүлээн авч үнэлгээ дүгнэлт хийж , хүн тус бүр дээр зөвлөгөө, өгч ажиллав. Цаашид анхаарах, сайжруулах, ямар чиглэлээр ажлаа тайлагнах гэх мэт зөвлөгөөг өглөө.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа явагддаг дотоод ажлын группыг 3 багшид хариуцуулж, цахим үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар шинэчилсэн журам боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлэв.

Бүтээлч чиглэлээр: Багш нар бүлгийнхээ дотоод группээр, мөн байгууллагын нэгдсэн группээр, эцэг эх болон хүүхдэд зориулсан халдвар хамгааллын дэглэм баримтлах чиглэл бүхий зурагт хуудас, видео шторк хийж хүргэж , танилцууллаа. Нийт 15 ш зурагт хуудас, 8 ш видео шторк хийж эцэг эх болон иргэдэд хүргэж ажилласан байна.

Энэ хугацаанд танхимийн сургалт 2 удаа, цахим сургалт 2 удаа зрхион явагдаж, ирц бүрэн 100% хамрагдсан байна.

Сарын үүрэг даалгаврын биелэлтийг дүгнэж, 19 ажилчин 100%, 11 ажилчин 86%, 7 ажилтан хангалтгүй түвшинд үнэлэгдэв. Эдгээр 7 ажилтанд цаашид ажил сайжруулах талаар хугацаатай үүрэг өгч ажиллаж байна.

Уурын зуух, хог хаягдлын цэг болон дотоод орчинд өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, ариутгал халдваргүйжүүлэлтийг 14 хоногт 1 удаа хийж байна. Хамт олны нэгдсэн уулзалт хэлэлцүүлгийг 3 удаа хийж, цаг үеийн мэдээ мэдээллээр хангаж, халдвараас урьдчилан сэргийлэх арга зүйн зөвлөмжийг цахим хаягаар, тогтмол өгч байна.

Багш ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр.

Нийт 39 багш ажилчид болон 7 ахмад багш нарт тус бүр 10 шуудай нүүрс олгож, түлээ нүүрсний дэмжлэг үзүүлж , 39 багш ажилчдад сар шинийн багц олгов.

Багш нарт бичиг хэргийн багц олгож, цахим үйл ажиллагааг дэмжиж 1сарын интернетийн эрхийн сунгалтыг хийж өглөө.

Дотоод зохион байгуулалт хийж, багш ажилчдыг 2 ээлж болгон хуваарийн дагуу ажиллуулж байна. Мөн 0-5 насны хүүхэдтэй ээжүүдийг гэрээсээ цахимаар ажиллах боломжийг бүрдүүллээ.

Соёл:

Байгууллагын 2022 онд ажиллах ажилчдын бүтэц орон тоог батлуулан 2021 оны үйл ажиллагааны тайлангаа засаг даргад танилцуулан ажиллаж байна.

2021 оны санхүүгийн тайланг хугацаанд нь Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газарт хүргүүллээ. Байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж 2022 оны төсвийн цалингийн сангаас 1%-д ахмадын сан байгуулахаар тусгасан.

Соёл урлагийн газарт 2022.01 сарын 20-ны дотор багтаан статистик тайлан мэдээг хүргүүлэн ажилласан. Соёл урлагийн газраас ирүүлсэн удирдамжийн дагуу Оны тэргүүнд нэр дэвшүүлэх ажилтнууд, байгууллагын материалыг хүргүүллээ.

Аймгийн онцгой комиссын хурлын шийдвэрийн дагуу 2022.01.15-аас эхлэн олон нийтийг хамарсан соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулаагүй.

Байгууллагын нийт ажилтнуудын 90%-нь 4-р тун вакциндаа хамрагдаад байна.

Соёл урлагийн үйлчилгээ:

Соёл урлагийн чиглэлээр байгууллагаас 2 удаагийн арга хэмжээ, гадны тоглолт 2 удаа нийт 4 удаагийн арга хэмжээнд 750 иргэдийг хамрууллаа.

Дуу бичлэгийн студийн өрөөг тохижуулах ажлыг хийж тоног төхөөрөмжийг байрлууллаа. Номын сангийн танхимын үйлчилгээг 65 үйлчлүүлэгчид, явуулын номын сангаар 26 иргэнд нийт 121 номоор үйлчилсэн байна.

Орон нутаг судлах танхимын тохижилт үйлчилгээ, хөшөө цогцолборын сэргээн засварлах ажлын зураг, ажлын тоо хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран хийлгэж байна. Сумын түүхт 100 жилийг ойг угтаж бэлтгэл ажил хангах зорилгоор соёл урлагийн чиглэлээр 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2022 оны 01 сарын 25 -ны байдлаар 44 өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний 32 насанд хүрэгчид, 12 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс Коронавирусийн халдвараар 20 хүн хэвтэж эмчлүүлсэн. Насанд хүрэгчид -16, хүүхэд байна.

Коронавирусийн халдвар 113 тохиолдол илэрсэнээс 4 хүн АНЭ-т шилжүүлсэн. Эмнэлэгт 20 хүн хэвтэн эмчлүүлсэн. Бусад 89 хүн гэрийн багц эмчилгээ авсан. Одоо 36 хүн гэрийн багц эмчилгээ хийлгэж байна.

Амбулаторийн үзлэг 365, урьдчилан сэргийлэх үзлэг 110 байна. Ковид-19 вакцины 1-р тунд 3614/3317 хүн буюу 91,7%, 2-р тунд 3614/3117 хүн буюу 86.2% , 3-р тунд хүн 2667 хүн хамрагдахаас 1439 хүн буюу 54.1%, 4-р тунд 77 хүн хамрагдаад байна. Түргэн тусламжийн дуудлага 48 ирснээс алсын дуудлага – 9 , ойрын дуудлага 39 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

Дөрөв: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

Аймгийн аварга малчин өрх шалгаруулах 2015 оны журмын дагуу 2-р багийн малчин Г.Мөнхбаатар,5-р багийн малчин Ж.Чогдорсүрэн,Г.Эрдэнэбат,Алтан төлийн эзэнд 5-р багийн малчин С.Чулуунцэрэн нарын материалыг аймгийн ХХААГазарт хүргүүлэн ажилласан. Сумаас аймгийн аварга малчин 3, Алтан төлийн эзэн 1 төрөн гарсан.

Сумын аварга малчинд 1-р багийн малчин Д.Чинзориг,2-р багийн малчин Г.Ариунзаяа,3-р багийн малчин О.Эрдэнэбаатар,4-р багийн малчин Б.Лхагвадорж,5-р багийн малчин Ж.Хүрлээ нарын материалыг сумын засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн сумын аварга малчнаар тодруулсан.

2021 онд Сумын хэмжээнд аймгийн аварга малчин -3,сумын аварга малчин -5 төрөн гарсан байна.

2021 оны ноосны урамшуулалд хамрагдсан 644 өрхийн падаан тулгалтыг аймгийн ХХААГазарт тулгалт хийж цахим мэдээлэлийн санд бүртгэлтэй 617 өрх, 2021 онд хийсэн ажлын тайлан, мэдээ, вакцинжуулалтын материал, ирсэн явсан бичгийг товъёоглон үдэж архивын нэгж болгоод байна. Бүртгэлгүй 27 өрхийг шивж баталгаажуулалтыг хийж ажилалаа.

Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч, тархвар зүйч нар 2022 оны ажлаа төлөвлөн, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан төрийн мэдээллийн цахим системд оруулан баталгаажуулаад байна.

2021 онд хэрэгжсэн “МАН-н эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд суманд сар бүр 5 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч 20 өрхийн 25 толгой малд халдварт өвчний эрт илрүүлгийг үзлэгийг хийсэн.

Энэ төслийн хүрээнд хийгдсэн ажлын дүнг тайлагнах хэлэлцүүлэгт 2022.01.17 өдөр Улаанбаатарт зохион байгуулагдахад тархвар зүйч оролцсон.

2022.01.21-нээс 22-ныг хүртэлх хугацаанд Улаанбаатар хотод МЭЕГ-аас зохион байгуулагдсан “Халдвар өвчний дата менежментийг ашиглах арга зүй” сэдэвт сургалтанд суралцаж сертификат авсан.

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Нэг: Хүрээлэн буй орчны талаар /холбогдох зураг/

Аймгийн засаг даргын 2021 оны 11 сарын 11-ны А/648 тоот захирамжийн дагуу сумын засаг даргын захирамж гарган “Агаар бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл”-ийг явуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 3-15квт 5-н багийн 550 өрхийн мэдээллийн санд оруулан ажиллаж байна.

Хоёр: Ногоон байгууламж, ургамал, бэлчээрийн талаар /холбогдох зураг/

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэсээс ирсэн бичгийн дагуу “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх ажлыг албан тоотоор цаг тухайд нь хүргүүлсэн.

Гурав: Мэдээллийн сан, сургалт сурталчилгаа, ИБХ-тай ажилласан талаар/ холбогдох зураг/

БОХ-1.3, БОХ-2.1, БОХ-2.2, БОХ-3.2, БОХ-4.2, БОХ-4.3 тайланг хугацаанд албан тоотоор холбогдох газарт хүргүүлсэн. 2022 онд хийх ажлын төлөвлөгөөг тамгын газарт өгсөн. Сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 15-ны өдрийн А/07 тоот тогтоол, хавсралт хуудас 30 / Нийт арга хэмжээ-5, нэгж талбар-112/-файлыг PDF өргөтгөлтэй цахим системд хавсралт хэсэгт оруулж дууссан. ГНС-ын тайланг загвар маягтаар гаргаж ГХБХБГазарт хүргүүлж дууссан. ГХБХБГазрын мэргэжилтэний зөвлөснөөр нэхэмжлэх үүсгэхийг түр хүлээлгэх шийдвэр өгсөн. Газар өмчлөгч 826 иргэний татварын ногдуулалтыг хийж, нэхэмжлэх үүсгэж дууслаа. Мөн 2021 оны зөрчилтэй 200 нэгж талбарын зөрчлийг арилгаж, ногдуулалт нэхэмжлэхийг нөхөн үүсгэж зөрчлийг арилган ажилласан.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.